



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/474

Мөрөн сум

Хяналт шалгалтын ажил зохион байгуулж,  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/155 дугаар тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 01/4517 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор ойн дагалт баялаг хуш модны самрыг хууль бусаар бэлтгэх, хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтын ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтын ажилд албан хаагчдаа томилж, хамтран ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ё.Пүрэвсүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Мөнхжаргал), Түнэл сумын Засаг дарга (Д.Цогбаяр), Тариалан сумын Засаг дарга (Х.Эгиймаа), Чандмань-Өндөр сумын Засаг дарга (Л.Энхжаргал), Цагаан-Үүр сумын Засаг дарга (А.Батмөнх), Эрдэнэбулган сумын Засаг дарга (Б.Эрдэнэнаран), Галт сумын Засаг дарга (Д.Эрдэнэхуяг), Жаргалант сумын Засаг дарга (Ц.Бямбажав) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Удирдамжийн хүрээнд хийгдэх ажлын 750,000 (долоон зуун тавин мянган) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА


П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671'011023



Аймгийн Засаг даргын 2023 оны 09  
дүгээр сарын 13-ны өдрийн А/47 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч - Э.Улам-Өсөх (аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Алтанцоож (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Ё.Пүрэвсүрэн (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Сумдын холбогдох төрийн албан хаагчид

Нарийн бичгийн дарга: Х.Хадбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга)



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр  
сарын 13-ны өдрийн А/474 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОЙН НӨӨЦ, ОЙН ДАГАЛТ БАЯЛГИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ,  
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр

**Зорилго:** Ойн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журмыг тус тус үндэслэн хууль бусаар бэлтгэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

**Хамрах хүрээ:**

1-р чиглэл – Тариалан, Эрдэнэбулган сумдын ойн сангийн нутаг дэвсгэр хамрагдана. Х.Хадбаатар - (аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга), А.Бат-Амгалан-(Тариалан сумын цагдаагийн тасгийн дарга, хошууч), А.Даваадорж (аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч), Б.Ганболд -(Улаан-Уул сумын Экологийн асуудал хариуцсан байцаагч), А.Батбаатар - (харуулын цагдаа, ахлагч), Н.Хадбаатар -(цагдаа, ахлах ахлагч), сумдын БОТХБТасаг, Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч хошууч (Ж.Нацагдорж).

2-р чиглэл – Галт, Жаргалант сумдын ойн сангийн нутаг дэвсгэр хамрагдана. Э.Нямдаваа - (аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны ахлах мэргэжилтэн), Б.Даваасүрэн-(аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч), Ч.Энхбат (Жаргалант сумын цагдаагийн тасгийн дарга, хошууч), Ц.Батсүх -(Цэцэрлэг сумын экологийн асуудал хариуцсан байцаагч, ахлах дэслэгч), Д.Өлзийсайхан -(Арбулаг сумын хэсгийн цагдаа, дэд ахлагч), Ч.Банзрагч -(цагдаа, ахлагч), аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч (Л.Бямбасүрэн).

3-р чиглэл- Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын чиглэлд П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга), Д.Сэнгэравдан -(Бүрэнтогтох сумын хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч), М.Буяннэмэх-(Чандмань-Өндөр сумын хэсгийн төлөөлөгч, дэслэгч), Б.Болдсайхан-(Хатгал тосгоны экологийн асуудал хариуцсан байцаагч, ахлах дэслэгч), Э.Шижирболд-(Цагаан-үүр сумын хэсгийн төлөөлөгч, дэслэгч), аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч (Н.Эрдэнэбилэг) нар ажиллана.

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Аймгийн цагдаагийн газрын хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Эрүүгийн хуулийн 24 зүйлийн 24.6.1 заалт "Хууль бус мод бэлтгэл"-ээс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хуулийн 7.9.6 заалт "Байгалийн дагалт баялаг самрыг хууль бусаар бэлтгэх" хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж гарсан зөрчлийг арилгах.

**Аймгийн Онцгой байдлын газрын хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих
- Сумын гамшгаас хамгаалах, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгах
- Ой хээрийн түймэр дээр ажиллах багажны хадгалалт хамгаалалтыг шалгах.



- Ойн мэргэжлийн байгууллагуудын галын аюулгүй байдлын бэлэн байдлыг шалгах.

**Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, "Байгалийн дагалт баялгийг хамгаалах зохистой ашиглах журмын хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчлах.
- Хушин ой бүхий газруудад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах
- Мод бэлтгэх эрхийн бичиг олголт, мод бэлтгэж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт тавих
- Иргэн, ААНБ-ын мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих
- Ойн ангийн үйл ажиллагаа ургуулж буй тарьц суулгац, ойн мэргэжлийн байгууллагын ойжуулалтын ажил /2022, 2023 онд байгуулсан мод бэлтгэх талбай тусгаарлах гэрээ, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байдал/ хяналт тавих
- Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байгуулсан гурвалсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
- 

**Ажил гүйцэтгэх хугацаа:** 2023 оны 09 дүгээр сарын 15-наас 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл

Сумдад ажиллах албан хаагчдын байр, хоолыг тухайн сум хариуцах, хяналт шалгалтыг хамтран зохион байгуулах байгууллага бүр 300,000 төгрөгийн шатахуун, сумдууд 300,000 төгрөгийн шатахууны зардлыг шийдвэрлэж ажиллах.

**Тайлан:** Удирдамжийн хүрээнд хийсэн ажлын тайланг 2023 оны 10-р сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллах.